



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/А12

Булган сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Нөөцийн газарт холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Аймгийн Засаг даргыг бүх шатны шүүхэд төлөөлөн оролцох итгэмжлэлийн хугацаа дууссан бөгөөд шүүхийн шийдвэр гарч хүчин төгөлдөр болсон тул иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд Аймгийн Засаг даргыг бүрэн төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга, Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Л.Лхамаа, Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн С.Амар нарыг 3 (гурав) жилийн хугацаатай томилсугай.

2.Хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шуурхай дуусгаж, дүнг танилцуулахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР